

**ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  
ЧАГНААГИЙН ГАНТУЯАГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь	
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	5			
1	2	3	4	6	7				
<b>Зорилт 1. Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлах, хэвлэл мэдээлэлтэй холбоотой ажлыг зохион байгуулах</b>									
1.	Арга хэмжээ 1.1. Байгууллагын үйл ажиллагаа, эрхлэх чиг үүрэгтэй холбоотой мэдээ, мэдээллийг боловсруулж, байгууллагын цахим хуудас болон цахим сүлжээнд байршуулж олон нийтэд ил тод мэдээлэх	Байгууллагын цахим хуудас, олон нийтийн цахим сүлжээнд байршуулсан мэдээллийн тоо	155/176	50	Тайлант хугацаанд байгууллагын цахим сайтад үйл ажиллагаатай холбоотой 39 мэдээ бэлтгэж, байгууллагын цахим сайтад нийт 79 мэдээ, ярилцлага, видео, нээлттэй мэдээлэл зэргийг байршуулж, олон нийтэд ил тод мэдээллээ. Мөн нийгмийн сүлжээ дэх байгууллагын цахим хуудаст нийт 110 мэдээлэл байршуулав. Цахим хуудаст тогтмол мэдээлэл байршуулж, түгээлт хийснээр байгууллагын цахим хуудас 26,663 дагагчтай, дундаж хандалт 135,763 болж ёссэн.	2024.12.01 2025.06.06			
2.	Арга хэмжээ 1.2. Байгууллагын үйл ажиллагаа, эрхлэх чиг үүрэгтэй холбоотой мэдээ, ярилцлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслийн таниулах	Сурталчилсан хэвлэл, мэдээллийн хэрэгслийн тоо	467	50	Бэлтгэсэн мэдээллийг давхардсан тоогоор 379 хэвлэл мэдээллийн хэрэгслээр (334 сайт, 14 сонин, 22 телевиз) сурталчилсан. Тухайлбал, “Виз, визийн зөвшөөрөл олголт 98.4 хувьтай байна” гарчигтай мэдээг 13 сайт, 2 телевизээр, “Гадаадын 653,545 иргэнд цахимаар үйлчилгээ үзүүллээ” мэдээг 11 сайт, 1 телевиз, 2 сонинд, “Өнгөрөгч онд 25 улсын 998 гадаадын иргэнийг албадан гаргалаа” гарчигтай мэдээг 24 сайт, 3 телевизээр, “Гадаадын иргэний оршин суух үнэмлэхийг киоск машинаас хэвлэж авах боломжтой боллоо” мэдээг 19 сайт, 2 телевиз, 2 сонинд, “2024 онд 30 улсын 2084 иргэнийг хил нэвтрүүлэлгүй буцаажээ” гарчигтай мэдээг 14 сайт, 2 телевизээр, “81 аж ахуйн нэгж,	2024.12.01 2025.06.06			

					байгууллага, 1786 гадаадын иргэнийг хяналт шалгалтад хамрууллаа" мэдээг 39 сайт, 2 телевиз, 2 сонинд, "Интерполоор эрэн сурвалжлагдаж байсан БНСУ-ын иргэнийг хяналт шалгалтаар илрүүллээ" мэдээг 25 сайт, 2 телевиз, 2 сонинд тус тус нийтлүүлж, олон нийтэд мэдээлсэн.		
3.	Арга хэмжээ 1.3. Байгууллагын үйл ажиллагааг гэрэл зураг, дурс бичлэгээр баримтжуулан, архивлах	Баримтжуулсан үйл ажиллагааны тоо	32	15	<p>2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр байгууллагын дарга <a href="http://tsahiuur.mn">tsahiuur.mn</a> сайтад цахим виз олголт, 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр tv5 телевизэд хил дээрээс буцаагдсан гадаадын иргэдтэй холбоотой асуудлаар ярилцлага, тодруулга өгөв.</p> <p>Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2024 оны 25 үйл ажиллагааны гэрэл зураг, видео бичлэг, бусад шаардлагатай 6 арга хэмжээний гэрэл зураг бүхий 45.0 GB хэмжээтэй, 35 хавтас файл баримтыг 2025 оны гуравдугаар сарын 28-ны өдөр архивд хүлээлгэн өгсэн.</p> <p>Тайлант хугацаанд 22 арга хэмжээний гэрэл зураг, видео бичлэг хийж баримтжуулан, архивласан байна.</p>	2024.12.01 2025.06.06	
Зорилт 2. Албаны үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээллүүдэд шинжилгээ хийж, гарсан нийтлэл, мэдээллийн мөрөөр арга хэмжээ зохион байгуулах							
1.	Арга хэмжээ 2.1. Байгууллагын үйл ажиллагаа, эрхлэх чиг үүрэг, албан хаагчидтай холбоотой хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан мэдээлэл, байгууллагын цахим хуудсаар иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн өргөдөл гомдолын агуулгыг удирдлагад танилцуулж, хариу арга	Гүйцэтгэлийн хувь	-	50	Байгууллагын цахим хуудас (Гадаадын иргэн, харьяатын газар / Immigration Agency Of Mongolia)-т иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн байгууллагын үйл ажиллагаа, эрхлэх чиг үүрэг, албан хаагчидтай холбоотой санал, хүсэлтийг хянаж, тухай бүр арга хэмжээ авч ажиллаж байна. Тухайлбал, 02 дугаар сарын 28-ны өдөр <a href="http://agar.mn">agar.mn</a> хаягаас гадаадын иргэний оршин суух үнэмлэхийг хуурамчаар үйлдсэн байж болзошгүй гэх мэдээллийг, 03 дугаар сарын 08-ны өдөр Agar <a href="http://agar.mn">agar.mn</a> хаягнаас ирүүлсэн "Хятад ажилчдад виз, оршин оршин суух гаргана" гэсэн цахим хуудас ажиллуулж байгаа талаарх мэдээллийг Дотоод хяналт, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтнүүдэд цахимаар хүргүүлсэн.	2024.12.01 2025.06.06	

	хэмжээ авах				2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр хаягнаас ирүүлсэн зөвлөгөө мэдээлэлтэй холбоотой сэтгэгдлийг нэгжийн даргад танилцуулж, Зөвлөгөө мэдээллийн хэлтсийн дарга шилжүүлж арга хэмжээ авсан.		
2.	Арга хэмжээ 2.2.  2024 оны хэрэглэгчийн үнэлгээний тайлан, судалгаанд тусгагдсан зөвлөмжийн дагуу хууль тогтоомж, үйлчилгээний шинэчлэлтэй холбоотой мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр бэлтгэж, шуурхай мэдээлэх	Бэлтгэсэн мэдээллийн тоо	-	3	<p>Оршин суух үнэмлэхээ өөрөө хэвлэн авах боломжтой киоск машиныг байршуулж, үйлчилгээнд нэвтрүүлсэн талаарх мэдээллийг монгол, англи хэлний сонголттойгоор 02 дугаар сарын 21-ний өдөр олон нийтэд мэдээлсэн. Мөн 55 секундын видео бичлэг бэлтгэж олон нийтэд хүргэсэн бөгөөд үзэлт, хандалт 19 мянга байна.</p> <p>Гадаадын иргэний бүртгэлтэй холбоотой 1 минут 5 секундын видео зааврыг бэлтгэж, 05 дугаар сарын 27-ны олон нийтэд хүргэсэн. Мөн постер мэдээллийг англи, хятад хэлний тайлбартайгаар олон нийтэд мэдээлсэн.</p> <p>Гадаадын иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад биечлэн ирэх шаардлагагүйгээр зөвлөгөө, мэдээлэл авах боломжтой цахим сувгуудыг сурталчилсан 4 цуврал постер-зурагт хуудас бэлтгэж 02 дугаар сарын 13-ны өдөр, байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол, санал гаргах хэлбэр, хүлээн авах мэдээллийн суваг болон өргөдөл, гомдолд тавих шаардлага, шийдвэрлэх, хариу өгөх зэрэг мэдээллийг багтаасан 4 цуврал постер-зурагт хуудсыг 05 дугаар сарын 20-ны өдөр байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэв.</p> <p>Мөн гадаадын иргэнийг бүртгүүлэх 5 шалтгаан бүхий 6 цуврал постерыг 06 дугаар сарын 02-ны өдөр олон нийтэд хүргэлээ.</p>	2024.12.01 2025.06.06	
3.	Арга хэмжээ 2.3.	Гүйцэтгэлийн		50	Тайлант хугацаанд нийгмийн сүлжээ дэх	2024.12.01	

	Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, хууль тогтоомжтой холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтийн цахим сүлжээ болон үйлчилгээ авсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад цахим шуудангаар түгээх ажлыг зохион байгуулах	хувь		байгууллагын цахим хуудаст үйл ажиллагаа, үйлчилгээ, хууль тогтоомжийг сурталчилсан нийт 110 мэдээлэл байршуулсан. Дээрх мэдээ, мэдээллийг "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 8.4.11-д заасны дагуу нийт албан хаагчид давхардан тоогоор 21230 түгээлт хийсэн байна. Тухайлбал, 2024 оны 12 дугаар сард 15 мэдээллийг 3478, 01 дүгээр сард 13 мэдээллийг 3507, 02 дугаар сард 20 мэдээллийг 4405, 03 дугаар сард 16 мэдээллийг 2989, 04 дүгээр сард 18 мэдээллийг 3009, 05 дугаар сард 21 мэдээллийг 3131, 06 дугаар сард 7 мэдээллийг 711 түгээсэн байна. Мэдээллийн дундаж түгээлт 193 байна. Мөн E-immigration системд бүртгүүлсэн 9000 хэрэглэгчдийн цахим шуудангаар байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, хууль тогтоомжтой холбоотой мэдээ, мэдээлэл илгээсэн. Тухайлбал, "Виз, визийн зөвшөөрөл олголт 98.4 хувьтай байна" мэдээг 01 дүгээр сарын 21, "Гадаадын иргэний оршин суух үнэмлэхийг киоск машинаас хэвлэж авах боломжтой боллоо" мэдээг 02 дугаар сарын 20, байгууллагын дарга tsahiur.mn сайтад цахим виз олголттой холбоотой асуудлаар өгсөн ярилцлага мэдээллийг 03 дугаар сарын 31-ний өдөр, гадаадын иргэний бүртгэлтэй холбоотой мэдээллийг 06 дугаар сарын 04-ны өдөр иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад цахим шуудангаар илгээсэн.	2025.06.06	
--	--	------	--	--	------------	--

## Зорилт 3. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх

1.	Арга хэмжээ 3.1. Хуулийн хүрээнд нээлттэй байлгахаар заасан, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн мэдээллийг нээлттэй байршуулж, тухай бүр	Нээлттэй мэдээлэл байршуулалтын хувь	82.3	50	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, байгууллагын даргын 2022 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн "Нээлттэй мэдээллийг нийтэд ил тод мэдээлэх ажлын зохион байгуулалтын тухай" А/135 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж, байгууллагын чиг үүрэг, стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан	2024.12.01 2025.06.06	
----	--	--------------------------------------	------	----	---	--------------------------	--

	шинэчлэх, ажлыг зохион байгуулж, хяналт тавих				авах ажиллагаа, үзүүлж буй үйлчилгээний талаарх 39 төрлийн мэдээллийг нээлттэй мэдээлж байна. Тайлант хугацаанд зохион байгуулалтын нэгжүүдээс ирүүлсэн 45 мэдээллийг нээлттэй байршууллаа. Үүнд:		
2.	Арга хэмжээ 3.2.  Холбогдох нэгжийн мэргэжилтнүүдэд хариуцсан чиг үүрэгтэй холбоотой удирдамж чиглэлээр хангаж, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	Гүйцэтгэлийн хувь		50	<p>Үйл ажиллагааны чиглэлээр 31</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын 14 мэдээлэл</li> <li>- Статистик тоон мэдээлэл 5 мэдээлэл</li> <li>- Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн 5 мэдээлэл</li> <li>- Үйл ажиллагааны тайлан 5 мэдээлэл</li> <li>- Төлөвлөгөө 2</li> </ul> <p>Хүний нөөцийн чиглэлээр 14</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүний нөөцийн бодлого, хөтөлбөр, холбогдох журмын талаар 4 мэдээлэл</li> <li>- Сонгон шалгаруулалтын мэдээлэл 5</li> <li>- Салбар зөвлөлийн мэдээлэл 1</li> <li>- Сургалтын төлөвлөгөө 1</li> <li>- Авлигын эсрэг үйл ажиллагааны 3 мэдээлэл байршууллаа.</li> </ul> <p>Гадаадын иргэн, харьяатын газар чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний талаарх мэдээллүүдийг Шилэн мэдээллийн сан (shilen.gov.mn)-д байршуулж, нэгдүгээр улирлын нээлттэй мэдээллийн үнэлгээ 99 хувтай үнэлэгдсэн.</p>	2024.12.01 2025.06.06	

					ирүүлсэн видео мэдээлэлд зөвлөгөө өгч, шаардлага хангасан “Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт” (50 секунд), “Төрийн албан хаагчид хориглох зүйл” (60 секунд), Авлигын хор хөнөөлийн таниулсан контент (1 минут 4 секунд)-ыг байгууллагын цахим хуудаст байршуулж олон нийтэд мэдээллээ.		
--	--	--	--	--	--	--	--

### Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
						1	2
1.	Байгууллагын даргаас өгсөн шуурхай үүрэг даалгаврыг хангах				<p>Байгууллагын даргаас өгсөн чиглэлийн дагуу</p> <ul style="list-style-type: none"> <li>- Олон улсын прокуроруудын холбооны Зүүн Европ, Төв Азийн хурал Монгол Улсад зохион байгууллагдахтай холбогдуулан Монгол Улсын визийн танилцуулга,</li> <li>- Монгол Улсад оршин сууж буй ОХУ, БНХАУ-ын иргэдийн сүүлийн 5 жилийн тоон үзүүлэлт бүхий танилцуулга,</li> <li>- Дээд шатны байгууллагуудад хүргүүлэх цахим виз, гадаадын иргэний бүртгэл, хяналтын тогтолцооны танилцуулгыг бэлтгэж, холбогдох тушаалтанд цахимаар хүргүүллээ.</li> </ul>	2024.12.01 2025.06.06	
2.	Gov.mn цахим хуудаст мэдээлэл байршуулах		-		2025.04.09-ны өдрийн 4/1867 тоот албан бичгийн ирсэн Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас /www.gov.mn/-т “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн дагуу 68 төрлийн нээлттэй мэдээллийг байршуулсан ажлыг зохион байгуулсан. Мөн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийт 104 мэдээллийг байршууллаа.	2024.12.01 2025.06.06	
3.	“Бөртэ” ТӨААТҮГ-тай хамtran ажиллах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллах		-		Байгууллагын даргын 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/192 дугаар дүрэмт хувцасны загвар шинэчлэх, техникийн баримт бичиг боловсруулах ажлын хурээнд “—” ТӨААТҮГ-тай хамtran ажиллах	2024.12.01 2025.06.06	

					үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажиллан 3 удаагийн уулзалтад оролцож, албан хаагчдаас хувцасны материалын санал авч хүргүүлсэн. Хээрийн хувцасны загвар боловсруулах хэмжээ өгөв. “...” ТӨААТҮГ-аас ирүүлсэн ёслол алба болон өдөр тутмын хувцас хийх материалыг ажлын хэсгийн дарга Ж. Солонгод танилцуулж, нэгжүүдийн албан хаагчдын саналыг уламжилсан. Мөн “...” ТӨААТҮГ-ын ерөнхий дизайнераас ирүүлсэн загварын талаар ажлын хэсгийн гишүүдтэй уулзаж, загварт тусгах үзүүлэлт, саналыг боловсруулж, хүргүүлсэн.		
4.	Аян зохион байгуулах ажлын хэсэгт ажиллах	-			Bайгууллагын даргын 05 дугаар сарын 26-ны өдрийн А/242 дугаар “Аян зохион байгуулах тухай” тушаалын төслийг боловсруулсан. “Бүртгэл: Хариуцлага, хамгаалалт” аяныг 05 дугаар сарын 26-ны өдрөөс 06 дугаар сарын 13-ны өдрийн хооронд зохион байгуулж байна.  Аяны хүрээнд гадаадын иргэнийг бүртгүүлэхийг уриалах, цахим бүртгэлийн ач холбогдлыг таниулах зорилгоор 3 видео, 8 постер хийж олон нийтэд түгээсэн. Мөн “Бүртгэл: Хариуцлага, хамгаалалт” аяны мэдээллийг 3 сайтаар сурталчиллаа.	2024.12.01 2025.06.06	
5.	7 хоног тутмын сурталчилгааны тойм гаргаж ХЗДХЯ-нд хүргүүлэх	-			XЗДХЯ-аас 2025 оны 05 дугаар сарын 21-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудалтай холбоотой хэвлэл мэдээллээр гарсан мэдээ мэдээллийн тоймыг 7 хоног тутам ирүүлэх чиглэл өгсөн. Үүний дагуу байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэгдсэн мэдээ, мэдээлэл, байгууллагын цахим хуудаст байршуулсан мэдээллийн тоймыг 7 хоногт бүр бэлтгэж, ХЗДХЯ-ны олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн ... цахимаар хүргүүлж байна.	2024.12.01 2025.06.06	

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	5		
1	2	3	4				6	7
1.	Арга хэмжээ 1. Орхон Их Сургуульд эрх зүйч мэргэжлээр бакалаврын зэрэг олгох сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан эсэх	-		2024 оны 10 дугаар сараас эхлэн мэргэжлийн ур чадвараа дээшлүүлж, эрх зүйч мэргэжил эзэмших зорилгоор Орхон их сургуулийн эчнээ ангид 2,5 жилийн хугацаатай суралцаж байна.		2024.12.01 2025.06.06	
2.	Арга хэмжээ 2. Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 сургалтад хамрагдах	Сертификатын огноо, дугаар	-	-	Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 сургалтад хамрагдаж 05 дугаар сарын 20-ны өдрийн 2025/2357 дугаар сертификат авсан.		2024.12.01 2025.06.06	
3.	Арга хэмжээ 3. “Монгол бичиг”-ийн цахим сургалтад хамрагдах	Сертификатын огноо, дугаар	-	1	Удирдлагын академийн Монгол бичгийн анхан шатны цахим сургалтад хамрагдаж, 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр №728424 дугаар сертификат авсан. Сургалтад хамрагдсанаар монгол бичгийн үсгүүдийг үзэж, монгол бичгийн хэл ба ярианы хэлний ялгааг мэдэж, эхийг уншиж, бичлэг, дуудлага ижил үгсийг бичих чадвар эзэмшсэн.		2024.12.01 2025.06.06	

ТАЙЛАН ГАРГАСАН:

ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ч. ГАНТУЯА / .....  
2025 оны 06 дугаар сарын 10